

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№20/524

ШУС, НУС

2019

МОНГОЛЫН СЭТГҮҮЛ ЗҮЙГ ҮНДЭСЛЭГЧИЙГ ТОДРУУЛАХ МАРГААН БА ТҮҮНИЙГ ХЭРХЭН ШИЙДВЭРЛЭСЭН ТУХАЙ

Л.Норовсүрэн*

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн гэрээт профессор, Шинжлэх ухааны доктор (Sc.D)

Түлхүүр үг: номлол, коммунист сургаал, итгэл үнэмшил, эрх мэдэл, хувьсгал, Цэвээн, чөлөөт хэвлэл, судлаачид, тусгаар тогтнол, уншигчид

1 1990 оны ардчилсан хувьсгал нийгмийн амьдралын бүх хүрээ, түүний дотор оюуны соёлын салбарт эрс эргэлт гаргасан билээ. Тийм түүхэн эргэлтийн явцад гарсан зөрчилтэй асуудлын нэг нь үзэл суртлын салбарынхан коммунист сургаалыг шүтэж ирсэн итгэл үнэмшлээсээ салж, шинэ үзэл номлолд дасан зохицох амаргүй зорилттой тулгарсан явдал байсан юм. Манай сэтгүүлчид “Монголын үнэн” сонины анхны дугаар гарсан 1920 оны 11 дүгээр сарын 10-ыг сэтгүүл зүй үүссэн өдөр хэмээн үзэж “Хувьсгалт хэвлэлийн өдөр” буюу сэтгүүлчдийнхээ баярыг тэмдэглэдэг байлаа. 1990 оноос тэрхүү уламжлал тасарсан юм. Учир нь коммунист байгууллаас татгалзчихаад түүний үзэл номлолыг сурталчилж байсан марксист хэвлэл үүссэн өдрөөр ойгоо тэмдэглэх нь хэт хуучинсаг явдал болох байв.

Зөвхөн энэ учраар “Хэвлэлийн өдөр”-өө тэмдэглэж чадахгүй эргэлзэн тээнэгэлзэж өнгөрөөсөн гурван жилд Монголд сэтгүүл зүйн эх суурь яг хэдэн онд тавигдсан, тэр нь ямар нэртэй

хэвлэл байсан, түүнийг үндэслэгч нь хэн байсан бэ? гэдэг асуудлаар хэвлэл мэдээллийн ажилтан, судлаачдын дунд ширүүн маргаан өрнөж байлаа. Тэр тухай өнөөдөр бодож үзэхэд маргаж мэтгэлцээд байх юмгүй мэт санагдаж болох боловч, тухайн цагтаа нэг хоёр эрх мэдэлтэй хүн сэтгэлийн хөдөлгөөнөөр шийдчих асуудал биш байсан юм.

Сэтгүүлч, судлаачид «Монголын үнэн» сониноор сэтгүүл зүйг овоглох нь учир утгагүй болсон гэдэг байр суурин дээр нэгдэж байсан ч, чухам ямар хэвлэлийг анхдагч гэж үзэх тухайд санал зөрөлдөж байлаа. Тэдний зарим нь 1921 оны үндэсний ардчилсан хувьсгал ялсны дараа гарч эхэлсэн Монгол Ардын Нам, Ардын засгийн газрын анхны албан ёсны хэвлэл-“Уриа”сонин гарсан өдрийг Хэвлэлийн өдөр болгох санал дэвшүүлж байхад, нөгөө зарим нь 1990 онд ардчилсан хүчнийхний гаргасан «Шинэ толь» сониныг санал болгож байв. Эхний саналыг гаргагчид туурга тусгаар улс болж нам, төр нь өөрийн гэсэн хэвлэлтэй болсныг үндэслэн «Уриа» сониныг дэвшүүлж байсан бол, хоёр дахь саналыг гаргагчид улс орон ардчилсан тогтолцоонд шилжсэн нөхцөлд ардчиллын баталгаа болсон жинхэнэ чөлөөт хэвлэл гарсан гэдэг утгаар нь «Шинэ толь»-ийг санал

болгож байв. Дээрх хоёр чиглэлийн эхнийх нь феодалын Монголын үед гарч байсан тогтмол хэвлэлийг сэргээн дурсахаас цэрвэж байсан бол, сүүлчийнх нь эрх баригч намын захиргаадлын зэвсэг болж байсан гэдэг үндэслэлээр хувьсгалт хэвлэлээс зай барьж байлаа. Аль аль нь үзэл сурталжиж туйлширсан санаа бодол байсан юм.

Монголын тогтмол хэвлэлийн түүхийг буурьтай судалсан том эрдэмтний гарын шавь болж, үндэсний сэтгүүл зүйн түүхийг сонирхон судалж, улмаар Их сургуульд сэтгүүл зүйн түүхийн лекцийг арав гаруй жил уншсан хүний хувьд миний бие тэр үед гуравдахь хувилбарын тухай бодож байлаа. Богд хаант Монгол улсын үед гарч байсан «Шинэ толь хэмээх бичиг», «Нийслэл хүрээний сонин бичиг» гэдэг хоёр сониныг хуучин тогтолцооны үед Феодалын нийгмийн хэвлэл гэдэг шалтгаанаар хэрэгсэж үздэггүй байв. Гэтэл ерээд онд тэр туйлшрал давтагдсан нь социализмын үеийн хэвлэлийг жинхэнэ сэтгүүл зүй биш гэж үзэх хандлага цухалзсан явдал байлаа.

Нэрт сэтгүүлч, доктор Г.Дэлэг Монголын хэвлэлийн түүхийн цуврал бүтээлдээ дээр дурьдсан хоёр сонины агуулгыг дэлгэрэнгүй өгүүлсэн боловч уг хоёр сониноор үндэсний сэтгүүл зүйн түүх эхэлсэн гэдэг үгийг барин тавин хэлээгүй байдаг. Эрх баригч нам «Монголын үнэн» сониныг сэтгүүл зүйн “Алтан хараацай” гэж өргөмжлөөд, тэр нь мэргэжлийн хүрээнийхний итгэл үнэмшил болчихсон нөхцөлд тэгэж хэлэх боломжгүй байсан нь мэдээж юм. Тэрээр, сонины эрхлэгч Ж.Цэвээний талаар нэн болгоомжтой хандаж байсан төдийгүй түүнийг «намын шугамаас гажсан барууны алдаа гаргаж, нийгэм-улс төрийн ажилд ноцтой эндэгдэл хийжээ. Цэвээний үзэл онолд гарч

байсан үндсэн алдаа нь тус орны капитализмыг алгасч социализмд шилжих ерөнхий шугамаас гажиж, бас монгол угсаатан гэсэн үндсэрхэх явцуу үзэл ягштал баримталж, Зөвлөлт Холбоот Улсын мөн чанарыг ойлгоогүй байсанд оршино»¹ гэж дүгнэсэн нь феодалын хэвлэлийг магтсан хэмээх зэмлэлээс мултрах хашир эрдэмтний арга байсан байх магадлалтай.

Ерээд оны тэр эргэлзээ тээнэ-гэлзлийн үед миний бодож байсан зүйл бол бид нийгмийн байгууллыг биш, тогтмол хэвлэлийн анхдагч хийгээд түүнийг эрхлэн гаргагч хэн бэ гэдгийг тодруулж тогтоох гэж байгаа биш үү? Дэлхийн жишгийг үзэхэд аль ч нийгэмд сонин, сэтгүүл гарч л байсан. Гэтэл тийм нийгэмд гарсан нь сонин мөн, өөр нийгэмд гарсан нь сонин биш гэж үздэггүй байна. Тэгэхээр 1913 онд гарсан «Шинэ толь хэмээх бичиг» чинь үндэсний сэтгүүл зүйн эхлэл, түүнийг эрхлэн гаргаж байсан Ж.Цэвээн үндэслэгч нь мөн гэсэн санаа байсан юм. Жирийн нэг багш надад индэр дээрээс үг хэлэх завшаан тэр бүр олдохгүй учир дээрх санаагаа зөвхөн ном бичгээр илэрхийлж эхэлсэн билээ.

Анхных нь, тэр үед санхүүгийн хомсдлоос үүдэн жижиг сонины хэлбэрээр гарч байсан «Сэтгүүлч» сэтгүүлд нийтлүүлсэн «Түүхэн үнэнийг хүндэтгэе»² гэдэг өгүүлэл байв. Тэр өгүүлэлд сонин сэтгүүл анх үүссэн тухай асуудлыг нийгмийн байгуулалтай хутган алагчилж, захчилж болохгүй. Ямар ч үзэл бодлыг номлож байсан цагаан цаасан дээр хараар бичээд сонин, сэтгүүл гээд гаргасан л бол түүнийг сэтгүүл зүйн үйл хэрэг мөн гэж хүлээн зөвшөөрөх ёстой. 1913 онд монгол хүн, монгол нутаг дээрээ «Шинэ толь хэмээх бичиг» гэдэг сонин гаргаад монгол орныхоо тусгаар тогтнолыг хамгаалах,

эдийн засаг, аж ахуйгаа хөгжүүлэх, хүн ардаа гэгээрүүлэхийн төлөө үгэн тэмцэл хийж байсан түүхэн үнэнийг хүндэтгэж 1913 оны 3 дугаар сарын 6-нд анхны дугаараа гаргасан «Шинэ толь хэмээх бичиг» сониноор үндэсний сэтгүүл зүйн түүх эхэлсэн, түүнийг эрхэлж гаргасан Ж.Цэвээн Монголын сэтгүүл зүйг үндэслэгч мөн гэсэн санаагаа илэрхийлсэн билээ. Уг санаагаа лавшруулж «"Шинэ толь хэмээх бичиг" Монголын ууган тогтмол хэвлэл мөн»³, «Ж.Цэвээн Монголын чөлөөт сэтгүүл зүйг үндэслэгч мөн»⁴, «Монголын сэтгүүл зүйг үндэслэгч Жамсрангийн Цэвээний тухай шинжилгээ»⁵ зэрэг өгүүллийг бичсэн билээ.

«Шинэ толь хэмээх бичиг» Монголын ууган тогтмол хэвлэл мөн» гэдэг өгүүлэлдээ тус сониныг эрхлэн гаргаж байсан Ж.Цэвээний амьдрал үйлс хийгээд түүнтэй хамт сонин гаргалцаж байсан Д.Бодоо, Д.Бадрахбаатар, Н.Жанцансамбуу нарын гүйцэтгэсэн үүрэг, тэдгээрийн нийтлэлийн зонхилох сэдвийн тухай өгүүлж, «Шинэ толь хэмээх бичиг» сонины эрхлэгч Ж.Цэвээн бол Монголын үндэсний сэтгүүл зүйг тогтмол хэвлэлийн уламжлалт хэлбэр болох сонин, сэтгүүл хоёрын аль алиных нь хэлбэрээр үүсгэсэн хүн гэсэн дүгнэлт хийсэн бол, «Ж.Цэвээн Монголын чөлөөт сэтгүүл зүйг үндэслэгч мөн» гэдэг өгүүлэлд «Шинэ толь хэмээх бичиг» сониныг чөлөөт хэвлэл гэж анх түрүүнд хэлсэн юм. Үнэнийг хэлэхэд тэгэж биччихээд "Тэр бүдүүлэг харанхуй үед чөлөөт хэвлэл гэж юу байдаг юм. Амныхаа зоргоор чалчсан байна" гэсэн эсэргүүцэлтэй тулгарах байх гэж эмээж байсан билээ. Онолын ёсоор бол санхүүгийн хувьд бие даасан, төр засгийн мэдлээс ангид, улс төрийн нам хүчнүүдээс

хараат бус, эрх зүйн орчин бүрдсэн нөхцөлд хэвлэл чөлөөтэй ажиллах боломжтой гэж үздэг. Гэтэл тийм орчин бүрэлдээгүй байх цагт тэрхүү хоосон орон зайд чөлөөт хэвлэл гаргаж болдгийг Монголын ууган тогтмол хэвлэлийн туршлага харуулсан юм. «Шинэ толь хэмээх бичиг» сониныг Богд хаант Монгол улсын засгийн газар санхүүжүүлж байгаагүйг Ж.Цэвээн нар «Бурхан багш», «Гүнгийн зуугийн гэгээний алтан сургаал» зэрэг бэсрэг товхимол хэвлэж, худалдан авахыг уншигчдаасаа хүсэх ялдамд өөр олон ном товхимол гаргахыг зорьж байгаа боловч "Манай сонин сангийн сонин лугаа адилгүй"⁶ гэж бэл бэнчин дутаж байгаагаа учирласнаас тодорхой мэдэж болно. Үүнээс үзвэл тус сонин эдийн засгийн хувьд хэнээс ч хамааралгүй байсан байна. Тэр үед улс төрийн нам, хүчин гэж байгаагүй учир хэвлэлд даралт шахалт үзүүлэх тухай яриа байсангүй. Урьд өмнө сонин хэвлэл гарч байгаагүй учир Богдын засгийн газар тогтмол хэвлэлтэй харилцах ямар ч туршлагагүй, тийм болохоор хэвлэлийн үйл ажиллагааг зохицуулах ямар нэг хууль дүрэм ч байсангүй. Сонины шүүмжлэлд өртсөн шар хар ихэс дээдэс «Шинэ толь хэмээх бичиг»-ийн талаар удаа дараа гомдол мэдүүлэхэд Богд хаан "Болгоомжтой үзэж байгун" гэдгээс өөр тодорхой шийдвэр гаргаж чадаагүй байдаг. Тогтмол хэвлэлийн түүх судлагч, Шинжлэх ухааны доктор Г.Дэлэг уг өгүүллийн талаар дүгнэж бичихдээ "Өгүүлэл хэдийгээр бүрэн нийтлэгдээгүй боловч Монгол улсын үндэсний тусгаар тогтнол, бие дааж хөгжих асуудал хийгээд дотоод байдлаа төвхнүүлэн сайжруулахыг дээрх этгээдийн хэн алинд ч итгэж хийх ба хангахад бэрхтэй гэсэн ойлголтыг уншигчиддаа төрүүлж, эд-

гээр этгээдэд аль нэг хамжээгээр жигших, итгэл алдаж сэжиглэх явдлыг төрүүлэхээр бичигджээ”⁷ гэсэн билээ.

Тийнхүү хар, шар эрхтнүүдийн дургүйцлийг төрүүлсэн нийтлэлийн оргил нь Ж.Цэвээний бичсэн “Их ноён Хуучин, мэргэн багш Ёст, орос Магад, хятад Ёслол нар цайлж ажиггүйн оронд зөвлөн тэмцсэн дөрвөн замын уулзвар нь” гэдэг өгүүлэл байв. Уг өгүүллийн талаар тухайн үед Монголд ажиллаж байсан элчин консул И.Я.Коростовец “Лам нар “Шинэ толь”-д нийтэлсэн зүйлийг шарын шашны сургаалтай харшилж, олны сүсэг бишрэлийг алдуулж эвдсэн зүйл гэж дургүйлхэв. Лам нар сэтгүүлийн эрхлэгч Цэвээнд нэн дургүйцэж, шаашин ба санваартны нэр хүндийг эвдэх гэсэн үл бүтэх этгээд гэж түүнийг үзэн ядаж байв”⁸ гэсэн бол академич Б.Ринчен “Шинэ толь” гэдэг тэр үедээ шинэ цагийн боловсрол түгээх зорилготой сэтгүүлийг Оросын консулын харьяанаа байсан орос үсгийн хэвлэлийн хорооны дэргэд байлгасан учир хуучин ёсыг хэрхэвч халахгүй гэсэн үзэл хадгалах ноёд түшмэд санааны дураар тэр бичгийг зогсоон хааж арай чадахгүй байсан гэж уг сэтгүүлийг нийтлэгч Цэвээн авгай ярьдаг сан”⁹ хэмээн дурссан байдаг.

Хэвлэл чөлөөтэй байгаагийн чухал шинжийн нэг нь эрх баригч

хүчнийг шүүмжилж чаддаг байх явдал билээ. Сониныг эрхлэн гаргагчид нийтлэлийнхээ бодлогыг хэнээс ч хамааралгүй тодорхойлж чаддаг байсны дээр зарчмын чухал асуудлаар Засгийн газрынхаа эсрэг байр суурь баримталж, шударга шүүмжлэлээ чөлөөтэй өрнүүлж чаддаг байжээ. Ялангуяа Богд хааны засгийн газрын урагшгүй ажиллагаа, сайд ноёдын улс орноо хөгжүүлэхийн оронд хувийн олз ашиг, нэр төрийг урьдал болгож байгаа бурангуй үйлсийг хурц шүүмжилж байсан юм. Бас Ш.Нацагдорж, Б.Ширэндэв нарын зэрэг судлаачид тухайн үед “Шинэ толь хэмээх бичиг” сонинны нийтлэлд төр, шашны эрх мэдэлтнүүд ихэд дургүйцэж байсан тухай өөрсдийн бүтээлд тэмдэглэсэн бий. Энэ нь сонин чөлөөтэй байсныг харуулж байгаа хэрэг юм.

Ийнхүү Ж.Цэвээний эрхэлж байсан «Шинэ толь хэмээх бичиг» үүлэн чөлөөний нар шиг тэрхүү сиймхийг ашиглан үгээ чөлөөтэй хэлж чаддаг байжээ гэсэн санааг «Ж.Цэвээн Монголын чөлөөт сэтгүүл зүйг үндэслэгч мөн» гэдэг өгүүлэлд дэвшүүлсэн билээ.

Дээр дурьдсан өгүүллүүд болон сэтгүүлчдийн дунд зохиогдсон уулзалт ярилцлагуудад дэвшүүлж байсан саналыг минь Монголын сэтгүүлчдийн VII их хурлын төлөөлөгчид нухацтай хэлэлцэж 1913 онд гарсан “Шинэ толь хэмээх



Дээр дурьдсан өгүүллүүд болон сэтгүүлчдийн дунд зохиогдсон уулзалт ярилцлагуудад дэвшүүлж байсан саналыг минь Монголын сэтгүүлчдийн VII их хурлын төлөөлөгчид нухацтай хэлэлцэж 1913 онд гарсан “Шинэ толь хэмээх бичиг”-ийг үндэсний тогтмол хэвлэлийн анхдагч гэж үзэн, жил бүрийн 3 дугаар сарын 6-ны өдрийг Монголын хэвлэлийн өдөр болгон тэмдэглэж байх тухайд санал нэгдэж, улмаар 1993 оны бүгд хурлаар тогтоол гаргаж баталгаажуулсанд судлаач хүний хувьд сэтгэл хангалуун явах болсон билээ



бичиг”-ийг үндэсний тогтмол хэвлэлийн анхдагч гэж үзэн, жил бүрийн 3 дугаар сарын 6-ны өдрийг Монголын хэвлэлийн өдөр болгон тэмдэглэж байх тухайд санал нэгдэж, улмаар 1993 оны бүгд хурлаар тогтоол гаргаж баталгаажуулсанд судлаач хүний хувьд сэтгэл хангалуун явах болсон билээ.

“Шинэ толь хэмээх бичиг” сонин Монголын тогтмол хэвлэлийн эхлэлийг чөлөөт хэвлэлийн шинжтэй тавьсан ууган сонин гэж үзэх миний саналыг анх түрүүнд дэмжиж үгээ хэлсэн судлаач бол доктор Т.Баасансүрэн мөн. Тэрээр энэ үзэл баримтлалаа 2002 оноос эхлэн тууштай илэрхийлж, нэг сэдэвт зохиолын түвшинд хүртэл лавшруулан авч үзсэн билээ. Т.Баасансүрэн 2009 онд хэвлүүлсэн “ХХ зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл” (Тэргүүн дэвтэр. I хэсэг) гэдэг бүтээлдээ “Шинэ толь хэмээх бичиг” сонин хувийн шинжтэй анхны хэвлэл байсан, улс төр, эдийн засгийн талаар Богд хааны Засгийн газраас хараат бус байсан, тухайн үеийнхээ эрх мэдэлтнүүдийг шүүмжилж, ил тод, олон ургальч үзлийн индэр болж чаддаг байсан тухай өгүүлээд “Шинэ толь хэмээх бичиг” сонин нь Монгол улсад гарч байсан хамгийн анхны чөлөөт ардчилсан хэвлэл мөн гэж үзэх бүрэн үндэстэй байна. Чухам үүгээр Ж.Цэвээн болоод түүний хамтран зүтгэгч сэтгүүлчид, “Шинэ толь хэмээх бичиг” сониноос Монголын хэвлэлийн түүхэнд оруулсан гайхамшигт хувь нэмэр, түүхэн чухал үүрэг тодорхойлогдоно”¹⁰ гэж итгэлтэйгээр хэлсэн билээ.

Т.Баасансүрэнг Монголын ууган тогтмол хэвлэлүүдийн тухай урьд өмнө судлаачдын хийсэн дүгнэлтүүдийг шинэ агуулгаар баяжуулсан эрдэмтэн гэж хэлж болно. Тэрээр, ялангуяа “Шинэ толь хэмээх бичиг” сонины талаар

шинэ үг хэлсэн юм. Тухайлбал сонин тухайн үедээ монгол улсын тусгаар тогтнолын бэлгэ тэмдэг болж байсан, тэрхүү тусгаар тогтнолыг хангах хөшүүрэг болсон аж ахуй, эдийн засгийн сэдвийг үндэслэл сайтай тусгаж байсан, соён гэгээрүүлэхийн зэрэгцээ илчлэн шүүмжлэх чиглэлийг тогтмол хэвлэлд оновчтой ашигласан, сэтгүүл зүйн туурвилын төрөл зүйл, хэл найруулгыг тогтоон төлөвшүүлэхэд анхдагч үүрэг гүйцэтгэсэн гэх зэрэг үнэ цэнэтэй дүгнэлтүүд хийсэнд талархах ёстой.

Үндэсний сэтгүүл зүй үүссэн үйл явдлыг үзэл суртлын хүлээс хийгээд улс төрийн явцуу эрх ашгаас салгаж, түүхэн үнэнийг баримтлах талаар гаргаж байсан чармайлт минь ажил хэрэг болж, өнөөдөр Монголын сэтгүүл зүйн түүхийн судалгаа зөв гольдролд орж, сэтгүүл зүйн үйл ажиллагаа шинэ нийгмийн үзэл баримтлалыг удирдлага болгон эрчимтэй хөгжиж байгаад баяртай явдаг билээ.

Ишлэл

- ¹ Дэлэг Г. 1965. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тойм. УБ., 107 дахь тал.
- ² «Сэтгүүлч» сонин. 1993. №3.
- ³ «Сэтгүүлч» сонин. 1993. №4.
- ⁴ МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг. (Нийгмийн ухаан). 1996. №2 (115).
- ⁵ ӨМИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг. Хөххот. 2004. №2 (112).
- ⁶ “Шинэ толь хэмээх бичиг” сонин. 1913. № 1.
- ⁷ Дэлэг Г. 1965. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ., 85 дахь тал.
- ⁸ Коростовец И.Я. 1927. Чингис хаанаас Зөвлөлт улс хүртэл. Берлин-Лейпциг., 251-252 дахь тал.
- ⁹ Ринчен Б. Монгол бичгийн хэлний зүй, хэлбэр судлалын удиртгал. УБ., 1-2 дахь тал.
- ¹⁰ Баасансүрэн Т. 2009. ХХ зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл. (Тэргүүн дэвтэр. I хэсэг). УБ., 105 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Дэлэг Г. 1965. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тойм. УБ.
2. «Сэтгүүлч» сонин. 1993. №3.
3. «Сэтгүүлч» сонин. 1993. №4.
4. МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг. (Нийгмийн ухаан). 1996. №2 (115).
5. ӨМИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг. Хөххот. 2004. №2 (112).
6. “Шинэ толь хэмээх бичиг” сонин. 1913. № 1.
7. Дэлэг Г. 1965. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ.
8. Коростовец И.Я. 1927. Чингис хаанаас Зөвлөлт улс хүртэл. Берлин-Лейпциг.
9. Ринчен Б. Монгол бичгийн хэлний зүй, хэлбэр судлалын удиртгал. УБ.
10. Баасансүрэн Т. 2009. XX зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл. (Тэргүүн дэвтэр. I хэсэг). УБ.
11. Норовсүрэн Л. 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Тэргүүн боть. УБ.
12. Норовсүрэн Л. 2013. Сэтгүүл зүйн онол, түүхийн асуудлууд. УБ.

Summary

This paper focuses on how journalism researchers argued on defining the originator of Mongolian national journalism. Author's position, that Tseveen Jamsran is the originator of Mongolian national journalism and celebration date of Mongolian national journalism is the 6th of March, 1913 as that day Mongolian first national periodical published its' first edition was supported by other researchers.